

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
2025 оны жилийн үйл ажиллагааны тайлан		
Тайлагнах хугацаа	2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Техник импорт ХК, УБГД: 9010001041 ҮЦК: 441 Утасны дугаар: (+976) 70001830,	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын Хөрөнгийн Бирж” ХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Гадаад, дотоод худалдаа, барилгын материалын худалдаа	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Сэрэлт дөл аудит ХХК 2019.08.28.	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	144,675.5	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албантушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий ня-бо С. Дашдулам ТУЗ-ын н.б.д О. Бүжинлхам Хянасан: Гүйцэтгэх захирал Д. Ганцэцэг	
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав.
	Орлогын тайлан	Тайланг хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав.
	Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав.
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	

	Техник импорт ХК нь санхүүгийн үйл ажиллагаагаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Монгол Улсад мөрдөгдөж байгаа НББ-ийн хууль тогтоомж, журам, зааврын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бүртгэл тооцоог явуулдаг. Техник импорт ХК нь 2025 оны жилийн санхүүгийн тайландаа СЗХ-нд бүртгэлтэй, аудит хийх тусгай зөвшөөрөлтэй “Сэрэлт дөл аудит” ХХК-иар аудит хийлгэсэн ба тус аудитын байгууллагын дүгнэлтээр, компанийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-д нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн зохицуулах Хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн, зөв илэрхийлэгдсэн байна”-гэж дүгнэгдсэн.	
1.2.	Аудитын компанийн дүгнэлтийг хавсаргав.	
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Тус компани 2025 оны санхүүгийн жилд 172 тэрбум 286,3 сая төгрөгийн борлуулалтын орлого олсон нь өмнөх оноос 31 тэрбум 584 сая төгрөгөөр буурсан байна. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 156 тэрбум 832,8 сая төгрөг болж борлуулалтаас олсон ашиг 15 тэрбум 453,5 сая төгрөг болсон нь борлуулалтын хэмжээ өмнөх оноос буурсан боловч борлуулалтаас олсон ашиг өмнөх оноос 2 тэрбум 167 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн бус үйл ажиллагааны орлого 1 тэрбум 209 сая төгрөг болж өмнөх оноос 221,2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Компанийн Ерөнхий ба удирдлагын зардал 5 тэрбум 164,2 сая төгрөг болж өмнөх оноос 372,7 сая төгрөгөөр өсчээ. Санхүүгийн зардал 5 тэрбум 568,7 сая төгрөг болж өмнөх оноос 108,2 сая төгрөгөөр буурчээ. Татвар төлөхийн өмнөх ашиг 5 тэрбум 502,8 сая төгрөг болж өмнөх оноос 1 тэрбум 703 сая төгрөгөөр өсчээ. Улсын төсөвт ААНОА татварт 551,3 сая төгрөг төлөхөөр тооцож тайлант үеийн цэвэр ашиг 4 тэрбум 951,4 сая төгрөгт хүрч өмнөх оноос 1 тэрбум 531 сая төгрөгөөр өссөн байна. Тус компани Улсын төсөвт 20,578, 336.9 төгрөг татвар төлжээ. Үүнд: ➤ ААНОА татварт 260,341.4 төгрөг

		➤ НӨАТ-д 17,524,548.5 төгрөг ➤ Гаалийн татварт 2,072,591.9 төгрөг ➤ НДШ-д 514,405.5 төгрөг ➤ Бусад татварт 206,449.6 төгрөг Эргэлтийн хөрөнгө оны эцэст 105 тэрбум 186,6 сая төгрөг байна. Үүнд: ➤ Мөнгөн хөрөнгө 765,5 сая төгрөг ➤ Бараа материал 21 тэрбум 484,9 сая төгрөг ➤ Дансны авлага 65 тэрбум 717,5 сая төгрөг ➤ Бусад авлага 17 тэрбум 208,2 сая төгрөг Дансны өглөг 40 тэрбум 68,1 сая төгрөг болж урьд оны төвшинд байна. Банкны богино хугацаат зээлийн өглөг 26 тэрбум 481,9 сая төгрөг болж өмнөх оноос 10 тэрбум 510 сая төгрөгөөр буурсан байна. Эргэлтийн хөрөнгөөр өр төлбөрөө төлөх боломж: $\frac{105 \text{ тэрбум } 186 \text{ сая /эргэлтийн хөрөнгө}}{76 \text{ тэрбум } 390,1 \text{ сая / өр төлбөр/}} = 1,38 \text{ буюу } 28 \text{ тэрбум } 796 \text{ сая төгрөг}$ Эргэлтийн хөрөнгөөр өр төлбөрөө төлөх боломж өндөр байна.
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдээр компани нь эргэлтийн хөрөнгөөрөө өр төлбөрөө барагдуулах боломжтойг харуулсан.
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Тайлант хугацаанд компани нь компанийн дүрэмд заасны дагуу гадаад, дотоод худалдаа, барилгын материал худалдан борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулсан. Компани нь МУ-ын зах зээл дээр нийлүүлэгдэж байгаа битумын 40%-ийг, цементийн 33%-ийг, арматурын 10%-ийг, мотоциклын 38%-ийг тус тус эзэлдэг. тайлант хугацаанд дараахь хүчин зүйлсийн нөлөөгөөр битум, цемент, мотоцикл, арматурын төлөвлөгөөт нийлүүлэлт, худалдан авалтууд тасарсан үзүүлэлттэй гарсан. Үүнд: 1. Ханшийн өсөлт /доллар, юань, рубль/ 2. Импортын барааны үнийн өсөлт /мотоцикл, битум/ 3. Инфляцийн өсөлт 4. Бэлэн мөнгөний хомсдол үүссэнээс бараа

		материал нийлүүлэх хугацаа удааширах, хойшлогдох 5. Байгалийн хүчин зүйлс /Бороо, үер ус/ 6. Хэрэглэгчийн худалдан авах чадваргүй байдал 7. Хөрш орнуудын улс төр, эдийн засгийн нөлөөгөөр бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт саатах /битум/ 2025 оны цемент, битум, мотоцикл, арматур, орон сууцны борлуулалтын хэмжээг 2024 онтой харьцуулвал: 1. Цемент 6.7% 2. Арматур 17% 3. Орон сууц 52,7%-ийн өсөлттэй гарсан бол 1. Битум 33% 2. Мотоцикл 30%-иар буурсан үзүүлэлттэй гарсан. Компанийн удирдлагаас бараа, бүтээгдэхүүний борлуулалтын бууралт, өсөлтөнд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлсүүдийг харгалзан үзэж аливаа ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг тодорхойлох, 2026 оны зах зээлийн судалгааг үр дүнтэй хийх, бараа материалын борлуулалтын төлөвлөгөөг судалгаа, эрсдэлийн үзүүлэлтүүдэд үндэслэн боловсруулж хэрэгжүүлэх, зах зээлд эзэлсэн байр сууриа бататгах, компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах санхүүгийн нөөц хөрөнгийг бүрдүүлэх, санхүүгийн сахилга бат, түүнд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, төлөвлөгөөний дагуу холбогдох ажлуудыг удирдлагаар ханган зохион байгуулж үр дүн, хэрэгжилтэнд хяналт тавьж компанийн үйл ажиллагааг хэвийн, доголдолгүй, үр бүтээлтэй явуулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хурлаараа Худалдаа хөгжлийн банкны Зээлийн хорооны хурлын шийдвэрийг үндэслэн Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналын дагуу Худалдаа хөгжлийн банкнаас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 10 тэрбум төгрөгийн зээл авах асуудлыг хэлэлцсэн. Тус хурлаас 10 тэрбум төгрөгийг 24 сарын хугацаатай, жилийн 16,3%-ийн

		хүүтэй авч ашиглах, банкны зээлийн барьцаанд зохих журмын дагуу компанийн үл хөдлөх хөрөнгө, ирээдүйн орлогоос орж ирэх мөнгөн хөрөнгийг барьцаалуулах эрхийг ТУЗ-ын 9 гишүүний 100 хувийн саналаар компанийн Гүйцэтгэх удирдлагад олгохоор шийдвэрлэсэн. СЗХ-ноос баталсан “Үнэт цаасны журам”-д заасны дагуу уг журамд заасан хугацаанд банкны зээлийн талаар хэлэлцсэн компанийн ТУЗ-ын шийдвэр, тогтоолыг холбогдох нотлох баримтын хамт СЗХ, Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж, биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажилласан. Тайлант хугацаанд компанийн Гүйцэтгэх удирдлага банкны зээлийг зориулалтын дагуу зарцуулж банкны зээлийг барагдуулж ажилласан.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.		
Цалин, урамшууллын мэдээлэл		
Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”, “Цалин, урамшууллын бодлогын журам”-аар олгосон эрх, үүргийн хүрээнд 2025 оны ХЭХ-аас баталсан ТУЗ-ын төсөвт заасны дагуу ТУЗ-ын 6 удаагийн хурлын цалинд зориулж ТУЗ-ын 9 гишүүнд 8 400 000 төгрөгийн цалин олгох, Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан “Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх гэрээ”-ний 1.3-т “Гүйцэтгэх захиралд сар бүр олгох цалингийн хэмжээ нь тогтмол байх ба жилийн эцэст ТУЗ нь компанийн жилийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, санхүүгийн үр ашгийн байдал, эд хөрөнгийн эзэмшил ашиглалт, хамгаалалт, хууль тогтоомжийн хэрэгжилт, ТУЗ-аас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, Гүйцэтгэх захирлын энэхүү гэрээгээр хүлээсэн бусад ажлын гүйцэтгэлийн үр дүн, дараа оны ажлын бэлтгэл, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан компанийн үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөний биелэлтийг үндэслэн Гүйцэтгэх захирал түүний удирдлагын багт шагнал, урамшуулал олгоно” гэж заасны дагуу гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж, гэрээний биелэлтийг дүгнэж цалин, урамшуулал олгох эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Мөн тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл ТУЗ-ын дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, ТУЗ-ын “Цалин, урамшууллын бодлого”-д заасны дагуу компанийн Гүйцэтгэх удирдлагаас инфляцийн өсөлттэй уялдуулан 2026 онд компанийн нийт ажилтнуудын цалинг 10-20 хувиар нэмэгдүүлэхээр ирүүлсэн саналыг хэлэлцэж шийдвэрлэсэн.		
Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл		

Техник импорт ХК нь 1958 онд байгуулагдсан, Монгол Улсын импортын ууган компани бөгөөд үйл ажиллагааны чиглэлийн дагуу гадаад, дотоодын олон байгууллагатай хамтран ажилладаг, зам, барилга, тээвэр зууч, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний худалдаа, хөдөө аж ахуйн салбарт өөрийн хувь нэмрээ оруулан ажилладаг, зах зээлд байр сууриа эзэлсэн, үнэ цэнэтэй харилцагчидтай, үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг хүлээсэн, мэргэжлийн ур чадвартай, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлсэн, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, 2 дугаар ангиллын нээлттэй хувьцаат компани билээ.

Компанийн удирдлагын бүтэц, үйл ажиллагаа

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал
2. Төлөөлөн удирдах зөвлөл
3. Гүйцэтгэх удирдлага

Хувьцаа эзэмшигчдийн хурал:

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм.

Тайлант хугацаанд Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулж хуралдуулах бэлтгэл ажлыг хангах, ХЭХ-ыг хуралдуулах, ХЭХ-ын шийдвэр, тогтоол, холбогдох нотлох материалуудыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д заасан хугацаанд хүргүүлэх үйл ажиллагаанд дараахь хууль тогтоомж, дүрэм журмуудыг удирдлага болгон эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

1. Техник импорт ХК-ийн ТУЗ-ын “2025 оны жилийн ажлын төлөвлөгөө”;
2. МУ-ын “Компанийн тухай хууль”-ийн 59.1, 60.1 дэхь заалт, 82 дугаар зүйл;
3. Компанийн засаглалын кодексе;
4. Үнэт цаасны зэх зээлийн тухай хууль болон Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”;
5. Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7 дугаар зүйл, 7.47.3, 7.47.3 дахь заалт;
6. Техник импорт ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.7.3, 2.7.4;
7. Техник импорт ХК-ийн “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ын 1.3.1, 5.1, 9.1, 9.2;

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм.

Дээрх хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулдаг бөгөөд ТУЗ-ын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоолын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2025 оны компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр холбогдох хууль, журмын дагуу амжилттай зохион байгуулж хуралдуулсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс Техник импорт ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд зориулж “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иас ирүүлсэн “Техник импорт ХК-ийн үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй болон хураангуй судалгаа”-ны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий Хувьцаа эзэмшигчдийг бүртгэж, баталгаажуулсан.

Техник импорт ХК-иас гаргасан нийт энгийн хувьцааны тоо 1,446,755 ширхэг бөгөөд ТУЗ-ын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоолд заасны дагуу 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргасан ҮЦТХТ ХХК-ийн “Техник импорт ХК-ийн үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй болон хураангуй судалгаа”-аар нийт 466 хувьцаа эзэмшигч компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэгдсэн.

ХЭХ-ын Тооллогын комисс үнэт цаас эзэмшигчдийн судалгаагаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8% нь буюу компанийн дүрэмд заасны дагуу нийт хувьцаа эзэмшигчдийн 60%-иас дээш хувьцаа эзэмшигчид оролцсоныг үндэслэн 2025 оны

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцож баталгаажуулсан.

ХЭХ-д саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцсоноос гадна ТУЗ-ын хараат болон хараат бус гишүүд биечлэн оролцож хурлын хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултанд хариулах, тайлбар, тодруулга хийж хууль, журамд заасан эрх, үүргээ хэрэгжүүлж ажилласан.

ХЭХ-ын дэгийн дагуу 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

1. 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
2. 2023 оны ногдол ашгийн тайлан, 2024 оны ногдол ашгийн талаарх ТУЗ-ын шийдвэр
3. 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан
4. 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө
5. 2024 оны ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан, 2025 оны ТУЗ-ын төсөв
6. 2025 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасны дагуу 2024 оны ТУЗ-ын гишүүдийн ажлын тайланг үндэслэн ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан дүгнэлтийг ХЭХ-д танилцуулж, 2025 оны ТУЗ-ын гишүүнээр Ж.Баярсайхан, Б.Батсайхан, Б.Нарантуяа, Т.Тунгалаг, Д.Баяраа, Э.Батболд, Ж.Уртнасан, С.Бүжинлхам, Г.Уран-Өлзий нарыг ТУЗ-ын гишүүнээр сонгох эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын дагуу Хувьцаа эзэмшигчид ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан саналыг хэлэлцэж компанийн засаглалын сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй, Компанийн тухай хууль, компанийн Дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тус тус заасан шаардлагуудыг бүрэн хангасан 2025 оны ТУЗ-ын хараат бус гишүүнээр Ж.Баярсайхан, Б.Батсайхан, Б.Нарантуяа нарыг, ТУЗ-ын ердийн гишүүнээр Т.Тунгалаг, Д.Баяраа, Э.Батболд, Ж.Уртнасан, С.Бүжинлхам, Г.Уран-Өлзий нарыг ТУЗ-ын гишүүнээр сонгож баталсан.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороог тус тус байгуулж бүрэлдэхүүнийг томилсон.

ХЭХ-ын Тооллогын комисс Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хурлаар хэлэлцсэн асуудал бүрээр шийдвэр гаргуулахтай холбогдуулан ТУЗ-ын гишүүдийг сонгох асуудлыг кумулятив аргаар, бусад хэлэлцсэн асуудлуудыг саналын хуудсаар санал авч, дүнг нэгтгэн гаргаж Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан.

Хуралд оролцсон нийт Хувьцаа эзэмшигчид хурлаар хэлэлцсэн асуудлуудыг бүрэн дэмжиж хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хуралдсан компанийн ХЭХ-аас гаргасан тогтоол шийдвэр, хурлын холбогдох баримт материалыг холбогдох хууль, журамд заасан хугацаанд СЗХ, МХБ ХК-д хүргүүлж биржийн цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажилласан.

2. Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл юм.

Холбогдох хууль, журмын дагуу компанийн ТУЗ-ын гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас, ТУЗ-ын даргыг нийт гишүүдийн олонхийн саналаар сонгож баталдаг.

2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас 9 нэр дэвшигчийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгож томилсон ба нийт 9 гишүүнээс 3 гишүүнийг ТУЗ-ын хараат бус гишүүнээр, 6 гишүүнийг ТУЗ-ын ердийн гишүүнээр сонгосон.

ТУЗ-ын гишүүдийг хүйсээр ангилбал 9 гишүүний 5 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй гишүүнээс бүрдсэн.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд Компанийн тухай хууль, компанийн Дүрэм, ТУЗ-ын үйл ажиллагааны журамд заасны дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

1. Банкны зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2025.02.04 №01/
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай /2025.02.14 №02/
3. Хамтарсан компанийн Гүйцэтгэх захирлыг томилох тухай /2025.02.26 №03/
4. Баталгаа гаргах тухай /2025.03.18 №04/
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай /2025.03.18 №05/
6. Банкнаас зээл авах эрх олгох тухай /2025.07.01 №06/

ТУЗ-ын 6 удаагийн хуралд 9 гишүүн оролцож хурлаар хэлэлцсэн асуудлыг 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

Мөн тайлант хугацаанд холбогдох хууль, журмын хүрээнд ТУЗ-ын дэргэдэх Хороод өөрсдийн чиг үүргийн дагуу холбогдох асуудлаар хуралдаж үнэлэлт, дүгнэлт гаргаж ажилласан. Үүнд:

1. ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо

- Дотоод аудитын 2024 оны жилийн ажлын тайланг хэлэлцэх;
- 2024 оны нэгж хувьцаанд ногдол ашиг олгох эсэх, компанийн 2024 оны үйл ажиллагааны болон жилийн эцсийн санхүүгийн тайланг хэлэлцэх;
- 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх компани сонгох;
- ТУЗ-ын Аудитын хорооны болон Дотоод аудитын албаны хагас жилийн ажлын тайланг хэлэлцэх;
- Компанийн хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх;
- 2025 оны компанийн Дотоод аудитын албаны ажлын тайланг хэлэлцэх;

2. ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо

- 2025 оны ТУЗ-ын гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэх;
- 2025 оны ТУЗ-ын гишүүдийн үйл ажиллагааны талаар хэлэлцэж дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулах;

3. ТУЗ-ын дэргэдэх Цалин, урамшууллын хороо

- Компанийн цалин урамшуулалтай холбоотой Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналыг хэлэлцэх;
- ТУЗ-ын 2024 оны төсвийн зарцуулалтын тайлан, 2025 оны ТУЗ-ын гишүүдийн цалин, төсвийг батлах асуудлыг хэлэлцэх;

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар олгогдсон эрх, үүргийн хүрээнд нийтдээ 6 удаа, ТУЗ-ын Аудитын хороо 6 удаа, нэр дэвшүүлэх хороо 2 удаа, Цалин урамшууллын хороо 2 удаа тус тус хуралдаж шийдвэр гаргаж ажилласан.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл ТУЗ-ын төсвийн дагуу “ТУЗ-ын 2025 оны сургалтын төлөвлөгөө”-г баталж төлөвлөгөөний дагуу ТУЗ-ын гишүүдийг ажил мэргэжил, харьяалагдсан хороодынх нь чиглэлийн дагуу шаардлагатай сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан ба 2025 оны сургалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээр ТУЗ-ын гишүүд 6 удаа, ТУЗ-ын нарийн бичгийн дарга 2 удаагийн сургалтанд тус тус хамрагдсан.

Холбогдох хууль, журамд заасны дагуу ТУЗ-аас тухай бүр мэдээлэх мэдээллийг заасан хугацаанд зохих журмын дагуу СЗХ, МХБ ХК-д хүргүүлж, биржийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажилласан.

Тайлант хугацаанд Техник импорт ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн үнэлгээний дагуу гаргаж СЗХ-нд тайлагнаж ажилласан.

Тайлант хугацаанд Зохицуулагч байгууллагуудаас албан бичиг, и-мэйлээр ирүүлсэн зөвлөмж, үүрэг даалгавруудыг биелүүлж ажилласан. Тухайлбал:

1. 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монголын хөрөнгийн бирж ХК-иас “Хамтран ажиллах тухай” 01/40 тоот албан бичгээр өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврыг заасан хугацааны дотор хэрэгжүүлж ажилласан. Үүнд:
 - Компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
 - 2024 оны ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ын шийдвэр
 - Компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл
 - Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл, холбогдох бусад хавсралт баримт материалууд
 - 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт
 - 2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан
 - Компанийн 2025 оны хагас жилийн санхүүгийн тайлан
 - Компанийн 2025 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан
 - МХБ ХК-д 2025 оны үнэт цаас гаргагчийн жилийн үйлчилгээний хөлс төлөх
2. 2025 оны 06 дугаар сарын 03-ний өдөр МХБ ХК-иас ирүүлсэн “Урилга хүргүүлэх тухай”

01/371 тоот албан бичгийн дагуу МХБ ХК-иас зохион байгуулж явуулсан хэлэлцүүлэг, арга хэмжээнд оролцсон.

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны эхний хагас жилийн компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг үнэлэх, зэрэглэл тогтоох ажлын хүрээнд компанийн “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн 2025 оны эхний хагас жилийн шинэчилсэн тайланг нотлох баримтын хамт ирүүлэхтэй холбогдуулан 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр албан бичиг /и-мэйл/, 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр албан бичиг /и-мэйл/-ээр өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

- Компанийн 2025 оны “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн шинэчилсэн тайланг хагас жилээр гаргаж Хороонд хүргүүлсэн.
- Компанийн засаглалын кодексын хэрэгжилттэй холбогдуулан Хорооноос өгсөн үүрэг даалгавруудыг засаглалын кодексын хэрэгжилтийн тайланд болон компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж холбогдох нотлох баримт материалын хамт Хороонд хүргүүлсэн.
- “Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн тайлангийн үнэлгээ”-ний дагуу 2025 оны 12-р сард холбогдох нотлох баримтуудын хамт тайлан гаргаж Хороонд хүргүүлсэн.

Тайлант хугацаанд буюу 2025 онд Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны ТУЗ-ын төсөвт заасан үнэлгээний дагуу ТУЗ-ын 6 удаагийн хурлын цалинд зориулж 9 гишүүнд 7 200 000 төгрөг, ТУЗ-ын нарийн бичгийн даргад 1 200 000 төгрөг, нийт 8.400.000 төгрөг олгосон.

Тайлант хугацаанд 2025 оны “ТУЗ-ын төсөв”-ийн дагуу ТУЗ-ын үйл ажиллагаанд нийтдээ 55 400 000 төгрөгийг зарцуулсан.

2025 оны ТУЗ-ын ажлын үр дүн, үнэлгээ:

- Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын баримт, материалыг хүлээж авч хянан үзээд “Техник импорт ХК нь 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Компанийн тухай хууль, Үнэт цаасны зэх зээлийн тухай хууль болон Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-д заасны дагуу хуралдуулсан тухай” албан бичгийг 2025 оны 07 дугаар сарын 03-ний өдөр 9/2704 тоот албан бичгээр компанид ирүүлсэн.
- Тайлант хугацаанд Монголын хөрөнгийн бирж ХК-д бүртгэлтэй 169 ХК-ийн “2025 оны жилийн эцсийн хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн судалгаа”-аар Техник импорт ХК нь 100 оноотой дүгнэгдсэн.
- Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо Техник импорт ХК-ийн “Компанийн засаглалын кодексын хэрэгжилт”-ийг үнэлэн, үнэлгээний тайлангийн хариугаар зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтэнд үнэлгээ өгч ажилласан бөгөөд 2025 оны жилийн эцсийн үнэлгээгээр Техник импорт ХК “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн үнэлгээгээр 2-р байранд орж үнэлэгдсэн.

3. Компанийн Гүйцэтгэх удирдлага

Тайлант хугацаанд компанийн Гүйцэтгэх удирдлага ТУЗ-аас байгуулсан “Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх гэрээ”-нд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажилласан.

Техник импорт ХК-ийн Гүйцэтгэх захирлаар 2006 оноос хойш Дашдондог овогтой Ганцэцэг ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн бүтцэд ямар нэгэн өөрчлөлт ороогүй бөгөөд компанийн бүтэц, зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх удирдлага компанийн дараах нэгж, албадын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, үйл ажиллагааны чиглэлийн дагуу үүрэг даалгавар, зөвлөмж өгч хэрэгжилтэнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

1. Гүйцэтгэх захирал

2. Дотоод аудитын алба
3. Захиргаа, хүний нөөцийн алба
4. Дэмжих үйлчилгээний алба
5. Инженер техникийн алба
6. Санхүү, бизнесийн алба
7. Бизнес хөгжлийн алба

Тайлант хугацаанд компанийн Гүйцэтгэх удирдлага 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас баталсан шийдвэр, тогтоол, компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ТУЗ-тай байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагааг доголдолгүй, үр ашигтай, хэвийн явуулахтай холбогдуулан дараахь ажлуудыг удирдан зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Үүнд:

1. Компанийн 2025 оны ХЭХ-аас баталсан бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хөрөнгө оруулагч, сонирхогч болон оролцогч талуудын хүсэлт, шаардлагад нийцүүлэн ажилласнаар харилцагч хэрэглэгчээ татаж хамрах хүрээ өргөжих, ажил үйлчилгээний хурд, шуурхай байдал, ажлын бүтээмж дээшилж, зарим бараа, бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэх үндэс болсон.

Тайлант хугацаанд компани нь 180 гаруй аж ахуйн нэгж, 6,200-гаад эцсийн хэрэглэгчтэй хамтран ажилласан. Тухайлбал мотоцикл, арматур, орон сууц, битум, цемент нийлүүлэх, худалдах чиглэлээр дараахь тооны аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллалаа. Үүнд: Мотоцикл 71, Арматур 19, Орон сууц 222, Битум 23, Цемент 72.

Сонирхогч байгууллагуудтай харилцах хүрээнд албан бичиг солилцох, биечлэн уулзах хэлбэрээр хамтран ажиллаж, тэдний санал хүсэлтийг барагдуулж 1,104 албан тоот илгээж, 362 албан тоот хүлээж авч ажиллахад үл ойлголцол, зөрчил гараагүй.

Мөн харилцагчийн тоог нэмэгдүүлэх, тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэх, бараа бүтээгдэхүүнээ зах зээлд сурталчлан танилцуулах, бараа бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, ажилтнуудын харилцаа, хандлага, ур чадварыг сайжруулахад онцгой анхаарч төрөл бүрийн мэргэжлийн шаардлагатай сургалтуудыг гадны холбогдох мэргэжлийн байгууллагуудаас авч ажилласан. 2025 онд 13 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 158 ажилтан хамрагдсан.

2. Компанийн удирдлага компанийн хэмжээнд ISO 9001 чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтэнд хяналт тавьж сайжруулах арга хэмжээ авч чанаржуулах, үр дүнг хангаж ажиллах чиглэлээр компанийн Дотоод аудитын алба болон алба нэгжийн дарга нарт хугацаатай үүрэг, даалгавар өгч үр дүн, хэрэгжилтийн талаар хариуцсан албадын дарга, холбогдох ажилтнуудаас тайлан авч үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгч удирдлагаар хангаж ажилласан.

3. Компанийн хэмжээнд галын аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажлыг зохион байгуулж явуулсан.

4. Эрхэлж буй ажлын онцлогтой уялдуулан компанийн ажилтнуудыг чанар, стандартын шаардлага хангасан өвөл, зуны ажлын хувцас, хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.

5. Компанийн ажилтнуудын тогтвор суурьшил, хариуцлага сахилга баттай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд анхаарч, нийгмийн асуудлыг шийдэх, ажлыг дэмжин туслах зорилгоор ISO 9001 стандарт хэрэгжүүлсэн хугацаанд ажиллагсдын хоол, хувцас, ажилтны хүүхдийн сургалт, орон сууцны урьдчилгаа, буцалтгүй тусламж, гадаадад аялуулах зэргээр нийгмийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэж ажилласан.

Компанийн Дотоод аудитын алба

2012 онд компанийн удирдлагаас компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж Гүйцэтгэх захирлын шууд удирдлаган дор ажиллах 2 хүний бүрэлдэхүүнтэй “Дотоод аудитын алба”-ыг анх байгуулсан. Энэхүү алба нь Гүйцэтгэх захирлаас өгсөн чиг үүргийн дагуу болон холбогдох дүрэм, журмаар олгосон чиг үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагаанд аудит хийж ТУЗ болон ТУЗ-ын Аудитын хороо, Гүйцэтгэх удирдлагаас тогтоосон хугацаанд аудитын ажлын тайлан, түүний үр дүнг тайлагнаж ажилладаг.

Тайлант хугацаанд компанийн Дотоод аудитын алба нь 2 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. 2022 оноос эхлэн компани нь үйл ажиллагаандаа “Олон улсын чанарын менежментийн тогтолцоо”-г хэрэгжүүлж ажилласан ба MNS/ISO9001:2015 стандартын шаардлагыг хангах ажлын хүрээнд Гүйцэтгэх захирал 2022 оны 03 сарын 10-ны өдрийн А-08 тоот тушаалаараа “Санхүүгийн дотоод аудитын журам”, “Чанарын дотоод аудитын журам”-ыг шинээр баталж компанийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. “Санхүүгийн дотоод аудитын журам”-ын дагуу компанийн үйл ажиллагаанд хийх “Санхүүгийн дотоод аудитын зорилго” нь толгой компани болон салбар, охин компаниудын санхүүгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэсэн болон борлуулж байгаа бараа бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил үйлчилгээ нь МУ-ын хууль тогтоомж, Гүйцэтгэх захирлын болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хуулийн дагуу эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг бол “Чанарын дотоод аудитын зорилго” нь Техник импорт ХК-ийн үйл ажиллагаа нь ISO 9001 стандартын дагуух чанарын менежментийн тогтолцооны шаардлагад нийцэж буй эсэх, хэрхэн үр нөлөөтэй хэрэгжиж байгааг тогтоох, нийлүүлэгчийг сонгох, захиалга хийх, бараа материал хүлээн авах, тээвэрлэх, хадгалах, борлуулалтын бүхий л шатанд чанартай үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, тэдгээрийн гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн үйл явц, үүрэг хариуцлагыг тогтооход чиглэгддэг. Тайлант хугацаанд Гүйцэтгэх захирлын тушаалын дагуу байгуулагдсан 6 гишүүнтэй Чанарын баг компанийн хэмжээнд чанарын дотоод аудитыг төлөвлөгөөний дагуу явуулж, үнэлгээ өгч ажилласан. Тайлант хугацаанд дотоод аудитыг холбогдох журмын дагуу компанийн бүх албадын хэмжээнд хийж, сайжруулалтыг ханган ажилласан. 2025 онд төлөвлөсний дагуу санхүүгийн болон дотоод аудитыг 09 сард хийж нийт 58 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ дүгнэлт өгөхөд зөрчил илрээгүй болно.				
Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл				
Тайлант хугацаанд “Эрсдлийг тодорхойлох, сэргийлэх арга хэмжээг төлөвлөх журам”-ын дагуу компанийн чиг үүргийн нэгж алба бүр үйл ажиллагааны гүйцэтгэлийн явцад бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт учирч болзошгүй эрсдэлээ тодорхойлж, түүнээс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган “Чанарын гарын авлага”-д тусгасны дагуу түүнийг мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Эрсдлийг Гадаад орчноос хамаарах, Дотоод үйл ажиллагааны гэж 2 ангилж дотор нь дэд бүлгүүдээр нарийвчлан гаргаж тодорхойлсон. Дотоод үйл ажиллагааны эрсдлийн аудитаар дотоод үйл ажиллагаанд тохиолдож болзошгүй 13 төрлийн 77 эрсдлээс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг мөрдөн ажилласны дүнд компанийн үйл ажиллагаанд эрсдэлт нөхцөл үүсч, үйл ажиллагаанд саад болсон тохиолдол гараагүй. Эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, шалтгааныг тогтоох өдөр тутмын гүйцэтгэлийн хяналт, дотоод болон гадаад аудит, Харилцагч, хэрэглэгчийн санал гомдолд үндэслэн явуулж байгаа гэж үзэж болно. Эрсдлээс сэргийлэх арга хэмжээг ажлын гүйцэтгэлтэй уялдуулах талаар Чанарын багийн гишүүд, Албадын дарга нар, менежерүүдэд сургалтаар танилцуулж, өдөр тутмын ажлын зааварчилгаа өгч, эрсдлээс сэргийлэх төлөвлөгөөг ажлын байр тус бүрт байршуулж, ашиглах боломжоор хангасан.				
Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/				
2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд зориулж “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иас ирүүлсэн судалгаагаар: Нийт хувьцааны тоо: 1, 446, 755 Хувьцаа эзэмшигчдийн тоо: 466				
№	Овог нэр	Хувьцааны төрөл	Эзэмшиж буй хувьцааны тоо /ширхэг/	Эзэмшиж буй хувь

1. Д.Ганбат	Энгийн	475161	32,84%
2. Д.Ганцэцэг	Энгийн	455736	31,5%
3. Г.Содбилэг	Энгийн	480300	33,2%
Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл			
Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлээгүй тул татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.			
Ногдол ашгийн мэдээлэл			
Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл жил бүр холбогдох хууль, журамд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ногдол ашгийн талаарх ТУЗ-ын тогтоол, шийдвэр, ногдол ашгийн тайланг танилцуулж тайлагнадаг. Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2024 оны нэгж хувьцаанд ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцсэн ба компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд үндэслэн 2024 оны нэгж хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Ногдол ашгийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг холбогдох хууль журамд заасан хугацаанд СЗХ, Хөрөнгийн биржид тайлагнаж ажилласан. Компанийн ТУЗ-ын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хурлаас гарсан ногдол ашгийн талаар гаргасан 03 тоот тогтоолыг 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 2023 оны ногдол ашгийн тайлангийн хамт танилцуулж хэлэлцүүлсэн.			
Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл			
Тайлант хугацаанд компаниас нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлсэн болно. Үүнд: 1. “Ахмадын өдөр”-өөр компанийн ахмад ажилтнуудыг хүлээн авч уулзалт зохион байгуулах, бэлэг, дурсгалын зүйл гардуулах; 2. Компанийн нийт ажилтнуудыг 2025 оны 09 сард Монгол-Японы хамтарсан эмнэлэгт гэрээний дагуу компанийн нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах; 3. Компанийн ажилтнуудыг өвөл, зуны ажлын хувцсаар хангах; 4. Компанийн 3 ажилтанд орон сууцны урьдчилгаа төлбөрт дэмжлэг үзүүлэх; 5. Компанийн 4 ажилтны 4 хүүхдийг “Оюутны тэтгэлэг”-т хамруулж оюутны тэтгэлэг олгох; 6. Компанийн ажилтнуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, спортоор хичээллэх, ажлын бус цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд зориулж нийт ажилтнуудын дунд спортын олон төрөлт тэмцээн уралдааныг зохион байгуулж дүгнэх, шагнал гардуулах;			

7. Компанийн ажилтнуудын хоолны зардлыг хариуцах;
8. Компанийн нийт ажилтнууд оролцох “Шинэ жил”-ийн баярын үйл ажиллагааг зохион байгуулж явуулах;
9. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр компанийн ажилтнуудын 150 хүүхдэд “Хүүхдийн баярын бэлэг” өгөх, мөн харьяа Баянгол дүүргийн 28-р хорооны 20 хүүхдэд бэлэг өгөх;
10. Шинэ байранд орох, хүүхдийн сэвлэг үргээх, компанийн “Шилдэг ажилтан”-аар шалгарч гадаадад аялах болон гүйлтийн марафон тэмцээнд оролцсон ажилтнууд, гэр бүлд тус тус буцалтгүй тусламж үзүүлэх;

Овог, нэр: Д.Ганцэцэг

Овог, нэр:

Албан тушаал: “Техник импорт” ХК-ийн

Албан тушаал: “..... ХХК-ийн

Гүйцэтгэх захирал

.....

Гүйцэтгэх захирал



(Handwritten signature)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2026.04.30

Овог, нэр: О.Бүжинлхам

Албан тушаал: ТУЗ-ын нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

(Handwritten signature: О. Бүжинлхам)